1-B, 2-A, 3-B, 4-C, 5-C, 6-A, 7-D, 8-C, 9-B, 10-C, 11-A, 12-B, 13-B, 14-A, 15-C, 16-D, 17-D, 18-A, 19-D, 20-B, 21-D, 22-C, 23-E, 24-A, 25-E, 26-C, 27-E, 28-D, 29-A, 30-A, 31-A, 32-C, 33-E, 34-E, 35-C, 36-A, 37-E, 38-A, 39-A, 40-A, 41-E, 42-E, 43-A, 44-C, 45-A, 46-E, 47-A, 48-B, 49-C, 50-E, 51-E, 52-E, 53-C, 54-E, 55-C, 56-C, 57-E, 58-E, 59-E, 60-E, 61-E, 62-A, 63-E, 64-E, 65-C, 66-A, 67-E, 68-C, 69-A, 70-C, 71-A, 72-A, 73-E, 74-C, 75-A, 76-B, 77-A, 78-A, 79-E, 80-D, 81-D, 82-A, 83-E, 84-A, 85-B, 86-E, 87-E, 88-E, 89-E, 90-C, 91-A, 92-D, 93-C, 94-D, 95-D, 96-A, 97-E, 98-C, 99-D, 100-B, 101-B, 102-D, 103-B, 104-D, 105-C, 106-A, 107-A, 108-C, 109-B, 110-B, 111-D, 112-B, 113-D, 114-D, 115-C, 116-A, 117-D, 118-B, 119-B, 120-A, 121-A, 122-E, 123-C, 124-C, 125-A, 126-D, 127-E, 128-E, 129-B, 130-D, 131-E, 132-A, 133-A, 134-E, 135-E, 136-E, 137-B, 138-A, 139-C, 140-B, 141-E, 142-A, 143-A, 144-E, 145-E, 146-A, 147-E, 148-E, 149-C, 150-D, 151-E, 152-A, 153-E, 154-C, 155-C, 156-E, 157-A, 158-B, 159-E, 160-C, 161-E, 162-A, 163-C, 164-A, 165-A, 166-D, 167-A, 168-A, 169-E, 170-A, 171-C, 172-E, 173-E, 174-D, 175-A, 176-C, 177-E, 178-E, 179-E, 180-B, 181-A, 182-C,

Сорил хариулах заавар:

1. Нэг сонголттой тест (Зөвхөн 1 хариулт зөв байх) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, Е гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
2. Олон сонголттой тест (Хэдэн ч хариулт зөв байж болох)
 - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
 - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
 - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
 - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
 - Бүх хариулт зөв бол (Е.)
3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
 - Зөв, Зөв, Зөв (А.)
 - Зөв, Зөв, Буруу (В.)
 - Зөв, Буруу, Буруу (С.)
 - Буруу, Зөв, Буруу (D.)
 - Буруу, Буруу, Буруу (Е.)

Сонгогдсон сорил:

- /1./ Жирэмсний эрт үеийн цус алдалт гэдэг нь
 - А. Жирэмсний I хагаст үтрээгээр цус гарахыг хэлнэ
 - В. Жирэмсний 20 долоо хоногоос дотогш үтрээгээр цус гарахыг хэлнэ
 - С. Жирэмсний 14 долоо хоногийн дотор үтрээгээр цус гарахыг хэлнэ
 - Д. Жирэмсний эхний 3 сарын дотор үтрээгээр цус гарахыг хэлнэ
 - Е. Жирэмсний 28 долоо хоногийн дотор үтрээгээр цус гарахыг хэлнэ
- /2./ Distantio trochanterica нь:
 - А. Дунд чөмөгний том төвгөрүүдийн хоорондох зай
 - В. Ташаа ясны дэлбээний алслагдсан зай
 - С. Ташаа ясны урд дээд сэртэнгийн хоорондох зай
 - Д. Умдагны дээд ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмын арын сэртэн хүртэлх хэмжээ
 - Е. Умдагны доод ирмэгээс хонцог хүртэлх хэмжээ
- /3./ Арын янз, дагз түрүүлэлтийн үед ургийн толгой ямар хэмжээгээр төрөх вэ
 - А. Бага ташуу

- В. Дунд ташуу
- С. Их ташуу
- Д. Босоо
- Е. Шулуун

/4./ Төрлөгийн явцад эмнэл зүйн уйтан аарцгийн шинж илэрсэн тохиолдолд төрлөг удирдах арга

- А. Өөрөөр нь төрүүлнэ
- В. Төрлөгийг сэдээж төрүүлнэ
- С. Яаралтай кесар хагалгаагаар төрүүлнэ
- Д. Ураг эвдэх ажилбар хийнэ
- Е. Төрөх үйл ажиллагааг зогсооно

/5./ Жирэмсний төгсгөл дэх умайн уртын хэмжээ

- А. 34-35см
- В. 35-36см
- С. 37-38см
- Д. 39-40см
- Е. 40-42 см

/6./ Дагз түрүүлсэн урд янз байхад төрлөгийн механизмийн эхний шат ямар байх вэ?

- А. Толгойн бөхийлт
- В. Толгойн гэдийлт
- С. Толгойн доошлолт
- Д. Толгойн хамгийн дээд гэдийлт
- Е. Толгой умдаг руу дагзаар эргэх

/7./ Жирэмсний ямар хугацаанд төмөр дутагдлын жинхэнэ цус багадалт үүсч хөгждөг вэ?

- А. 8 д/х
- В. 12 д/х
- С. 16 д/х
- Д. 20 д/х
- Е. 28 д/х

/8./ Ихэс түрүүлсэн байж болзошгүй гэж таамаглаж байгаа үед онош тодруулахаар үтрээний үзлэгийг хаана хэдийд хийх вэ?

- А. Амаржих газрын хүлээн авахад ирэнгүүт
- В. Хэсгийн эмнэлэгт үзүүлэхээр ирэхэд
- С. Амаржих газар мэс заслын өрөөнд хагалгааны бэлэн байдал хангасан үед
- Д. Түргэн тусламжийн эмч гэрт нь
- Е. Амаржих газрын үзлэгийн өрөөнд

/9./ Ураг орчмын шингэн хэдийд гарахыг цагтаа гарлаа гэж үзэх вэ?

А. Төрөлтийн | үе эхэлснээс хойш умайн амсар 4 см нээлттэй байхад ургийн шингэн гарвал

- В. Төрөлтийн | үе дуусч умайн амсар бүрэн нээгдэхэд шингэн гарах
- С. Төрөлтийн үйл ажиллагаа эхлээгүй байхад ургийн шингэн гарах
- Д. Төрөлтийн 2-р үе эхэлж дүлэлт өгснөөс хойш
- Е. Төрөлтийн үйл ажиллагаа эхлэхэд

/10./ Бага аарцгийн аль хэсэгт ургийн толгой дотор эргэлт хийж дуусах вэ

- А. Аарцгийн хөндийн өргөн хэсэгт
- В. Аарцгийн хөндийн уйтан хэсэгт
- С. Аарцгийн ёроолд
- Д. Аарцгийн хөндийн өргөн хэсгээс уйтан хэсэгт шилжих үед
- Е. Аарцгийн орох хэсгээс хөндийн хэсэгт шилжихэд

/11./ Леопольдын 3-р барилаар юуг тодорхойлох вэ?

- А. Түрүүлсэн хэсэг
- В. Ургийн нуруулалт
- С. Ургийн байрлал
- Д. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцгийн орох хэсэгт тавигдсан эсэх
- Е. Ургийн янз

/12./ Жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэр, төрөлтийн I үед амьдралын чухал үзүүлэлтүүдийг ямар хугацаанд үзэж хянах вэ?

- A. 20 минут тутамд
- B. 15 минут тутамд
- C. 10 минут тутамд
- D. 30 минут тутамд
- E. 25 минут тутамд

/13./ 20-21 см нь аарцгийн ямар хэмжээс вэ?

- A. Distantio spinarum
- B. Conjugata externa
- C. Distantio cristarum
- D. Conjugata interna
- E. Conjugata diagonalis

/14./ Дараах үед партограмм хөтөлж эхэлнэ

- A. Төрөлтийн 1-р үеийн идэвхтэй шатнаас
- B. Төрөлтийн нууц үед
- C. Умай базалж эхэлмэгц
- D. Эмэгтэйг төрөх өрөөнд хүлээн авах үеэс
- E. Дунших үеэс

/15./ Амаржих газрын 1 эхийн оронд ноогдох талбай

- A. 3м²
- B. 5м²
- C. 7м²
- D. 9м²
- E. 10 м²

/16./ Төрөлтийн 2-р үед хэдий үеэс эх барихын гардан тусламж үзүүлж эхлэх вэ?

- A. Умайн амсар бүрэн нээгдсэн үеэс
- B. Ургийн толгой бага аарцгийн гарах хэсэгт тулж ирсэн үеэс
- C. Ургийн толгой цухалзах үеэс
- D. Ургийн толгой цухуйсан үеэс
- E. Ургийн толгой гарах үеэс

/17./ Уйтан аарцагтай үед жирэмсний эхний хагаст гарах хүндрэл

- A. Жирэмсний эрт хордлого үүснэ
- B. Үр хөврөл, ургийн өсөлт удааширна
- C. Зулбахаар завдана
- D. Жирэмслэлт хэвийн явагдана
- E. Ихсийн дутмагшил үүснэ

/18./ Ураг дагуу байрлалтай, ар янзын дагз түрүүлэлт, 2-р хэлбийлттэй үед толгой аарцгийн амсарт тавигдах үеийн байдлыг хэлнэ үү.

- A. Суман заадас баруун ташуу хэмжээнд бага зулай баруун ардаа
- B. Суман заадас зүүн ташууд бага зулай зүүн ардаа
- C. Суман заадас баруун ташууд бага зулай зүүн урдаа
- D. суман заадас зүүн ташууд бага зулай баруун урд
- E. Суман заадас хөндлөн хэмжээнд бага зулай зүүн талд

/19./ Өвөр янз, дагз түрүүлэлтийн үед ургийн толгойн бэхлэх цэг хаана байх вэ?

- A. Дагзны төвгөр
- B. Дагзны төвгөр, цох
- C. Дагзны хонхор, духны үстэй хэсгийн зааг
- D. Дагзны хонхор
- E. Духны үстэй хэсгийн зааг

/20./ Ургийн толгойн их хөндлөн хэмжээг дурьдана уу.

- A. 13 см
- B. 9. 25 см
- C. 10. 5 см
- D. 13. 5 см
- E. 8 см

/21./ Хамгийн олон тохиолддог ургийн түрүүлэлт юу вэ?

- A. Цэвэр өгзөг
- B. Хөл өгзөг
- C. Хөл түрүүлэлт
- D. Толгой түрүүлэлт
- E. Нүүр түрүүлэлт

/22./ Ихэс түрүүлэх үед ихсийн байрлал хаана байх вэ?

- A. Умайн их биед
- B. Умайн хүзүүний сувагт
- C. Умайн доод таславчинд
- D. Умайн ёроолд
- E. Умайн их биед урд хананд

/23./ Аарцгийн уйтралын зэргийг ямар хэмжээгээр тогтоох вэ

- A. Ташаа ясны урд дээд сэртэн хоорондын зай
- B. Гадна шулуун хэмжээ
- C. Дунд чөмөгний толгойн том төвгөр хоорондын зай
- D. Ташаа ясны дэлбээний алслагдсан зай
- E. Жинхэнэ шулуун хэмжээ

/24./ Ихэс гардах ажилбарын үед хийх бэлтгэл

- 1. Үйлдлийг эхэд тайлбарлана
- 2. Судсанд шингэн залгасан байна
- 3. Өвчин намдаалт хийнэ
- 4. Давсаг суллах шаардлагагүй
- 5. Цэвэрлэх бургуй тавина

/25./ Гүйцэд ургийн шинж:

- 1. Урт нь 48-57 см
- 2. Жин нь 2500 гр-с дээш
- 3. Арьс ягаан
- 4. Мөчдийн хөдөлгөөн идэвхтэй
- 5. Өөхөн эдийн хөгжил сайн

/26./ Жирэмсний хожуу хордлогын хөнгөн хэлбэртэй байхад төрөлтийн III үеийг яаж удирдах вэ?

- 1. Ихэсийг шууд гардана
- 2. Артерийн даралт, судасны цохилтыг үзнэ
- 3. Умай агшаах эмийг хэрэглэх шаардлагагүй
- 4. Идэвхтэй аргаар удирдана
- 5. Хүлээх тактик баримтална

/27./ Төрсний дараах халдвараас хэрхэн сэргийлэх вэ?

- 1. Төрөлтийн үед халдваргүйжүүлэх дэглэмийг чанд сахих
- 2. Төрөлтийн үед ажилбар хийгдсэн бол антибиотик эмчилгээ хийх
- 3. УОШ хугацаанаасаа өмнө ба эрт гарсан тохиолдолд олон удаа үтрээний үзлэг хийхгүй байх
- 4. Жирэмсэн үед архаг халдварын голомтыг эмчилж эрүүлжүүлэх
- 5. Жирэмсэн үед бүх төрлийн шинжилгээнд хамруулах

/28./ Тулгарсан зулбалтын үед ямар эмчилгээг хийхгүй вэ

- 1. Хэвтрийн дэглэм
- 2. Тайвшруулах эм уулгах
- 3. Витамин эмчилгээ
- 4. Бэлтгэл хийж умайн хөндийг цэвэрлэх
- 5. Умайн булчинг сулруулах

/29./ Жирэмсний бөөлжилтийн дунд хэлбэрийн үед хийх асаргаа сувилгаа:

- 1. Арьсыг чийгшүүлэх тос түрхэнэ
- 2. Эмнэлэгт хэвтүүлж судсаар шингэн сэлбэнэ
- 3. Шээсний гарцыг хэмжих
- 4. Амаар хооллохгүй
- 5. Уух шингэнийг багасгах

/30./ 32 долоо хоног ба 40 долоо хоногтой жирэмсэнг хэрхэн ялган оношлох вэ?

1. Хэвлийн тойргийн хэмжээгээр
2. Ургийн уртаар
3. Хүйсний байдлаар
4. Умайн ёроолын өндрөөр
5. Ургийн байрлалаар

/31./ Зүрх судасны өвчтэй төрөгч эхийн төрөлтийн үеийн асаргаа сувилгаа:

1. Төрөлтийн үед чийглэсэн О 2 өгнө
2. Артерийн даралт, судасны цохилт, амьсгалын тоог тогтмол 30 минут тутам хянана
3. Төрөлтийн I үед эхийг хажуугаар нь хэвтүүлнэ
4. Төрөгч эхэд шингэн их дутагдах тул I үед шингэн ихээр уулгана
5. 0.9% натри хлорид сэлбэнэ

/32./ Бага аарцгийн хөндийн өргөн хэсгийн хэмжээнүүд аль нь вэ?

1. Нэргүй шугамын алслагдсан зай-13 см
2. Хоёр талын сүүжний хонхруудын дотор зай-12. 5 см
3. Хоёр талын суудлын төвгөрүүдийн хоорондох зай-11 см
4. Умдагны үений дунд дотор голоос ууцны II. III үеийн зааг хүртэл-12. 5 см
5. Умдагны үений дунд дотор голоос ууц-ахар сүүлний үе хүртэл -11. 5 см

/33./ Үтрээний үүрэг:

1. Хамгаалах үүрэгтэй
2. Үр тогтолтонд оролцдог
3. Төрөх замын зөөлөн хэсэг болдог
4. Биений юмны цус дамжин гадагшилдаг
5. Умайн хүзүүний шүүрэл гадагшилна

/34./ Хярзан сэтлэх заалт:

1. Суналт муутай өндөр хярзан
2. Хярзан урагдахаар завдсан
3. Дутуу төрөлт
4. Урагт бүтэлт үүсч байгаа
5. Том ураг

/35./ Ураг хөндлөн байрлалтай үед үтрээний үзлэгээр юу тодорхойлогдох вэ?

1. Ургийн өгзөг тэмтрэгдэнэ
2. Ургийн хавирга, хавирга хоорондын завсар, суга
3. Ургийн өвдөг өгзөгтэй хамт тэмтрэгдэнэ
4. Бугуй, гарын сарвуу, гар унжих
5. Хөлийн тавхай, шилбэ, өвдөг

/36./ Цус алдалтын үед илрэх ерөнхий шинж тэмдгүүд;

1. Артерийн даралт буурч, судасны цохилт олширно
2. Үтрээнээс цус гарна
3. Арьс салст цонхийж цайн хүйтэн хөлс гарна
4. Артерийн даралт ихсэн, амьсгал цөөрнө
5. Судасны хүчдэл нэмэгдэнэ

/37./ Тамхи нь үр хөврөл, урагт дараах эмгэгийг үүсгэнэ:

1. Үр хөврөл аяндаа зулбах
2. Мэдрэлийн гажиг
3. Дутуу төрөх
4. Амьгүй төрөх
5. Ургийн өсөлт хоцрогдох

/38./ Өртөмтгий жирэмсэн эмэгтэйг хэн илрүүлэх вэ?

1. Сумын эмч
2. Өрхийн эмч
3. Сумын эх баригч
4. Зөвхөн эх барих эмэгтэйчүүдийн эмч
5. Сувилагч

/39./ Эх барихын үжлийн үед дорхи үзүүлэлтүүдийг 2-3 цаг тутамд хянаж өвчний түүхэнд тэмдэглэнэ

1. Арьсны байдал
2. Биеийн халуун
3. Ялгарч буй шээсний хэмжээ
4. Цусан дахь сахарын хэмжээ
5. Төвийн венийн даралт

/40./ Төрөх хугацааг олохдоо:

1. Ураг анх хөдөлсөн өдөр дээр тулгар төрөгчид 20 долоо хоногийг нэмнэ
2. Овуляци болсон өдөр дээр 42 долоо хоногийг нэмнэ
3. ССТ ирсэн сарыг 3-р урагшлуулж, эхний өдөр дээр 7-г нэмнэ
4. Ураг анх хөдөлсөн өдөр дээр давтан төрөгчид 20 долоо хоногийг нэмнэ
5. Үзлэгээр хүйсний хонхор тэгширсэн

/41./ Эх барихын гадуур үзлэг хийх бэлтгэл:

1. Эмэгтэйг шээлгэсэн байна
2. Эх баригч гараа дулаацуулсан байна.
3. Эмэгтэйг орон дээр хэвтүүлж, хөлийг өвдөг түнхний үеэр хагас нугалуулна
4. Хийх үйлдлээ тайлбарлана
5. Жирэмсний сүүлийн 3 сартайгаас эхлэн хийнэ

/42./ Жирэмсний хожуу хордлогын хөнгөн хэлбэртэй байхад төрөлтийн II үеийг яаж удирдах вэ?

1. АД. УЗЦ -ийг дүлэлт бүрийн дараа үзнэ
2. АД-ийг эмээр буулгасан байна
3. Ургийн толгой хязсанд хүртэл доошлохыг хүлээнэ
4. Төрөлтийн 2-р үеийг богино байлгах
5. Ураг бүтэхээр завдвал өвчин намдаалтын дор хяззанг сэтлэх

/43./ Төрсний дараах үеийн цус алдалт үргэлжилж, цусны хэмжээ 1000 мл- ээс их болсон тохиолдолд эх баригч дорхи арга хэмжээг авна

1. Мэргэжлийн эмчийг яаралтай дуудна
2. 2 том хураагуур судсанд шингэн залгана
3. Мэс заслын өрөөг бэлэн байлгана
4. Цус цусан бүтээгдэхүүн шууд сэлбэнэ
5. Цус бүлэгнүүлэх эмчилгээ хийнэ

/44./ Хяззан хамгаалах үйлдэл:

1. Толгой цухалзах үеэс эхлэн үзүүлнэ
2. Гарын алгаар урагдахаас сэргийлж хяззанг аажим сунгана
3. Үтрээний ханыг 2 хуруугаар сунгаж тэлнэ
4. Толгой цухуйх үеэс эхлэн үзүүлнэ
5. Зулайн төвгөр төрөхөд үзүүлнэ

/45./ Эхэлсэн зулбалтын үед дараах шинж илэрнэ

1. Хэвлийн доогуур хүчтэй базална
2. Үтрээнээс цусархаг ялгадас гарна
3. Умайн хүзүү нээгдсэн
4. Умай жирэмсний хугацаатай тохирохгүй
5. Умайн хүзүү хаалттай

/46./ Ураг орчмын шингэний ач холбогдол:

1. Ураг чөлөөтэй өсөж хөгжих. хөдлөх нөхцлийг бүрдүүлнэ
2. Ургийг гадаад орчны таагүй нөлөөнөөс хамгаална
3. Ургийн бодисын солилцоонд оролцоно
4. Умайн хүзүү нээгдэхэд тусална
5. Хүй дарагдахаас хамгаална

/47./ Умайн хүзүүг шалгах заалт

1. Төрсний дараа үтрээгээр цус гарсан тохиолдол бүрт
2. Төрсний дараа үтрээгээр цус гарсан, умайн агшилт сайн
3. Тулгар төрөгч бүрт
4. Давтан төрөгч
5. Умайн агшилт сул бол

/48./ 10 сартай ургийн онцлог биш шинжийг дурьдана уу?

1. Арьсны өнгө улаан
2. Бүх биеэр шар үстэй
3. Жин нь 2400 гр-аас бага
4. Урт нь 45 см
5. Рефлекс сул

/49./ Хэвийн жинтэй жирэмсэн эмэгтэйд биеийн жин дунджаар хэдэн кг нэмэгдэх вэ?

- A. 6-8 кг
- B. 8-9 кг
- C. 9-12 кг
- D. 13-15 кг
- E. 15-17 кг

/50./ Цус алдсан эхэд хийх асаргаа сувилгаа:

1. Дулаан байлгана
2. Давсаг суллана
3. Шингэн сэлбэнэ
4. Умайн агшилтыг хянана
5. Алдсан цусыг зөв хэмжсэн байна

/51./ Архи үр хөврөлд ямар нөлөөтэй вэ?

1. Оюун ухааны хомсдол
2. Жижиг тархитай төрөх /микроцефали/
3. Ургийн хөгжил хоцрогдох
4. Зүрхний гажиг
5. Уруул, тагнайн сэтэрхий

/52./ Өртөмтгийн хүчин зүйлүүдийг нэрлэнэ үү?

1. Эрхтэн тогтолцооны эмгэгийн өчил
2. Эх барихын ужиг дурьдатгал
3. Нийгэм биологийн хүчин зүйлийн дурьдатгал
4. Тухайн жирэмсний хүндрэл
5. Хожуу анхан төрөгч

/53./ Төрсний дараах үеийн цус алдалтын ангилалд аль нь хамаарагдахгүй вэ?

- A. Төрсний дараах эрт үеийн цус алдалт
- B. Төрсний дараах үеийн анхдагч цус алдалт
- C. Төрсний дараах хожуу үеийн цус алдалт
- D. Төрсний дараах үеийн хоёрдогч цус алдалт
- E. Төрсний дараах хурц, архаг цус алдалт

/54./ Төрсний дараах үжил ямар нянгуудаар үүсгэгддэг вэ?

1. Стафилококк
2. Стрептококк
3. Гэдэсний савханцар
4. Мөөгөнцөр
5. вирус

/55./ Жирэмсэн магадгүй байхад толины шинжилгээгээр ямар өөрчлөлт илрэх вэ?

1. Умайн хүзүүнээс салиархаг ялгадас элбэг гарах
2. Үтрээний салст хөхөлбий болох
3. Үтрээний ялгарлын хэмжээ нэмэгдэх
4. Умайн хүзүүний салст хөхөлбий өнгөтэй
5. Үтрээний үүдэвчийн салст ягаан болох

/56./ Жирэмсэн үед шээс ялгаруулах эрхтэн системд дараах өөрчлөлт гарахгүй:

1. Давсаг дээш татагдана
2. Шээсний гарц багасна
3. Умай, ургийн толгой давсгийг дарна
4. Шээс үүсэх процесс хурдасна
5. Шээсний суваг тахиралдаж гогцоорно

/57./ Зүрх судасны өвчтэй жирэмсэн эхчүүдэд өгөх зөвлөгөө

1. Хоногийн давсны хэмжээ 5 гр хүртэл
2. Биеийн жинг 7 хоног тутам хэмжих

3. Хоногт 10 цаг унтаж амрах
 4. Ханиад хүрэх, хоолой өвдөхөөс сэргийлэх
 5. Ачаалал шаардсан ажил хийхгүй байх
- /58./ Эр бэлгийн эсийн онцлог
1. 1 мин-д 3 мм хурдтай хөдөлнө
 2. Толгой, хүзүү, сүүлнээс тогтоно
 3. Шүлтлэг орчинд тэсвэртэй
 4. Шингэний урсгалын эсрэг хөдөлдөг
 5. Гиалуронидаза, трипсин төст ферментүүдийг ялгаруулна
- /59./ Төрөлтийн II үеийн тусламж:
1. Төрөгч эмэгтэйг төрөх орон дээр гаргах
 2. Зөв дүлэхийг заах
 3. Гадна бэлэг эрхтэнг антисептик уусмалаар угаах
 4. Хярзанг хамгаалах
 5. Эх барих тусламж
- /60./ Эмнэл зүйн уйтан аарцаг үүсэхэд юу нөлөөлдөг вэ?
1. Том ураг
 2. Илүү тээлт
 3. Толгойн хазгай тавилт
 4. Ар янзын нүүр түрүүлэлт
 5. Ургийн тархи усжих
- /61./ Төрөлтийн II үеийн асаргаа сувилгаа:
1. Орны дэрийг өндөрлөнө
 2. Дүлэлт бүрийн дараа УЗЦ-г чагнана
 3. Артерийн даралтыг тогтмол хянана
 4. Зөв дүлүүлнэ
 5. Гадна бэлэг эрхтэнг ариутгана
- /62./ Биений юмны мөчлөгийн өндгөвчийн үе шатыг хэлнэ үү?
1. Фолликул өсөж хөгжих
 2. Өндгөн эс гадагшлах
 3. Шар бие үүсч хөгжих
 4. Умайн үйл ажиллагааны давхарга хуурах
 5. Умайн салст нөхөн төлжих
- /63./ Төрсний дараа эх нярайг үзэж, хянах товллын хугацааг хэлнэ үү.
1. Эхний 24 цагийн дотор
 2. Төрсний дараах 3 дахь хоног
 3. Төрсний дараах 7 дахь хоног
 4. Төрсний дараах 5-6 дахь долоо хоногт
 5. Шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзахгүй үзнэ
- /64./ Төрөлтийн үеийн өвдөлтийн мэдрэмжийг бууруулах аргууд
1. Төрөлтийн I үед алхах, суух зэргээр тохиромжтой байрлалыг сонгоно
 2. Ууц нуруунд иллэг хийх
 3. Өвдөлтийн үед зөв амьсгалах
 4. Сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх
 5. Өөрийн хүссэн хүнээр туслуулах
- /65./ Михельсоны ромбо нь юуг илэрхийлэх вэ?
1. Аарцаг ясны зузаан
 2. Босоо хэмжээ нь жинхэнэ конъюгатыг тодорхойлно
 3. Аарцаг ясны эзэлхүүн
 4. Аарцаг ясны хэлбэр
 5. Аарцгийн хазайлтыг тодорхойлно
- /66./ Бага аарцгийн орох хэсгийн хэмжээнүүд аль нь вэ ?
1. Нэргүй шугамын алслагдсан зай-13 см
 2. Ташуу хэмжээ-12 см
 3. Умдагны үений дээд ирмэгээс ууцны төвгөр хүртэл-11 см
 4. Хоёр талын сүүжний хонхруудын дотор зай-12 см

5. Умдагны үений доод ирмэгээс ууц-ахар сүүлний үе хүртэл-11. 5 см
- /67./ Төрөлтийн III үед:
1. Ихэс салсан шинжүүдийг үзэх
 2. Ураг төрөнгүүт давсгийг суллах
 3. Орны дэрийг буулгах
 4. Ихсийг идэвхтэй аргаар удирдах
 5. Умайд иллэг хийх
- /68./ Илүү тээгдсэн нярайн онцлог шинж:
1. Арьсны өнгө хэвийн, шар үс ар нуруугаар байна
 2. Арьс хуурай, мацерацийн өөрчлөлттэй
 3. Бэлгийн их уруул нь бага уруулаа давсан
 4. Толгойн яс хатуу, зулайнууд багассан
 5. Рефлексийн хөгжил сайн
- /69./ Хярзан урагдах аюул тулгарсны шинж:
1. Хярзангийн эд тэлэгдэж түмбийнэ
 2. Хярзангийн арьс хөхөрч цайрна
 3. Хярзангийн арьс язарч эхэлнэ
 4. Хошноого хунигч булчин урагдана
 5. Үтрээний салст урагдсан байна
- /70./ Үр хөврөл, ургийн сонсголын аппаратыг юунаас бусад нь гэмтээх вэ?
1. Ампициллин
 2. Стрептомицин
 3. Оксациллин
 4. Гентамицин
 5. Цефазолин
- /71./ Леопольдын 2-р барилаар юуг тодорхойлох вэ?
1. Ургийн байрлал
 2. Ургийн хэлбийлт
 3. Ургийн нуруулалт
 4. Ургийн түрүүлсэн хэсэг бага аарцагт тавигдсан эсэх
 5. Ургийн түрүүлсэн хэсэг
- /72./ Төрсний дараа цус их хэмжээтэй алдсан үед цаашид ямар хүндрэл үүсэх вэ
1. Сүүний гарц багасна
 2. Шиханы хам шинж
 3. Иценго- Кушингийн хам шинж
 4. Биений юмны өмнөх хам шинж
 5. Умайн үйл ажиллагааны алдагдлын цус алдалт
- /73./ Үтрээний 2 гарын хавсарсан үзлэгээр юуг тодорхойлох вэ?
1. Умайн байрлал
 2. Умайн хэлбэр
 3. Умайн цуллаг
 4. Дайвруудын байдал
 5. Аарцгийн эзэлхүүн
- /74./ 10 сартай ургийн онцлог биш шинжийг дурьдана уу?
1. Шар үс дал мөрөөр
 2. Арьсны өнгө улаан
 3. Толгой уртын 1/3 -ийг эзэлнэ
 4. Жин нь 2400 гр
 5. Амьдрах бүрэн чадвартай
- /75./ Судсаар шингэн юүлэхийн өмнө анхаарах зүйл
1. Шингэний савны бүрэн бүтэн байдал, лацыг шалгах
 2. Шингэний хүчинтэй байх хугацаа
 3. Уусмалд тунадас байгаа эсэх
 4. Уусмалын үнэр
 5. Уусмалын орчин
- /76./ Жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэр

1. Шээсэнд уураг 2(+)
2. АД 150/110
3. Сулралын даралт 110 мммуб-с их
4. Шээсний гарц хоногт 400 мл-с бага
5. Хөл шилбээр хавантай

/77./ Эхэс умайн хананаас салаагүй, төрөх замаас цус гарч байгаа үед та ямар арга хэмжээ авах вэ?

1. Яаралтай эхэс гардана
2. Умайн хөндийг шалгаж, хавсарсан иллэг хийнэ
3. Ажилбарын дараа үрэвслийн эсрэг эмчилгээ хийнэ
4. Хойдохыг өөрөө салахыг хүлээнэ
5. Креде Лазеривичийн аргаар эхэсийг төрүүлнэ

/78./ Үтрээний үзлэгийг хэдийд хийх вэ?

1. Жирэмсэн ба төрөгч эх хүлээн авахад ирэхэд
2. Ургийн шингэн гарахад
3. Төрөгч эхэд 4 цаг тутамд
4. Дүлэлт эхлэх үед
5. Шаардлагатай үед хугацаа харгалзахгүй

/79./ Ихэсээр дамжин халдварлуулах үүсгэгчид

1. Томуу
2. Цитомегаловирус
3. Улаанбурхны вирус
4. Тэмбүүгийн үүсгэгч
5. ДОХ-ын вирус

/80./ Цус алдалтын дайрлагын хүнд хөнгөний зэргийг дараах лабораторийн шинжилгээг харгалзан дүгнэнэ.

1. Артерийн даралт
2. Төвийн венийн даралт
3. Биеийн халуун
4. Цусны гематокритйн хэмжээ
5. Судасны цохилт

/81./ Юунаас бусад нь эх барихын тусгайлсан асуумжинд хамаарагдах вэ?

1. Жирэмслэлтийн тоо
2. Үр хөндөлт
3. Урьд нь дутуу төрж байсан эсэх
4. Бага насандаа өвчилсөн өвчнүүд
5. Амьгүй ураг төрүүлж байсан

/82./ Манас таталтын урьдлын хөнгөн хэлбэрийн үед илрэх шинжийг нэрлэ:

1. Хавагнах
2. Артерийн даралт ихсэх
3. Шээсээр уураг ялгарах
4. Толгой өвдөх
5. Аюулхай орчим өвдөх

/83./ Умайн хүзүүний бэлтгэлийн зэргийг дараах шинж чанараар илэрхийлдэг

1. Умайн хүзүүний байрлал
2. Умайн хүзүүний сувгийн урт
3. Умайн хүзүүний амсрын хатуу зөөлөн
4. Умайн хүзүүний нээгдлийн хэмжээ
5. Умайн хүзүүний толийлт

/84./ Төрөлтийн үйл ажиллагаа эхэлсний шинж:

1. Умайн базлалт жигд
2. Умайн хүзүү нээгдэж эхэлнэ
3. Үтрээнээс цусархаг салиа гарна
4. Ургийн толгой аарцгийн орох хэсгийн дээр
5. Төрөгч эхэд дүлэлт үүснэ

/85./ Ихэс ховхрох үед ямар шинж илрэх вэ?

1. Үтрээнээс нөжтэй цус гарна
 2. Хэвлийгээр өвдөнө
 3. Артерийн даралт буурна
 4. Ургийн жижиг хэсгийг тэмтрэхэд бэрхшээлтэй
- 5УЗ цохилт өөрчлөгдөнө

/86./ Үтрээний 2 гарын хавсарсан үзлэгээр юуг тодорхойлох вэ? Давхардсан байна

1. Умайн байрлал
2. Умайн хэлбэр
3. Умайн цуллаг
4. Дайврууд
5. Аарцгийн эзэлхүүн

/87./ Орчин үеийн төрлөг удирдах аргын үндсэн гол асуудлууд:

1. Партограмм хөтлөх
2. Өвдөлтгүй төрүүлэх аргыг зөв сонгож хэрэглэх
3. Төрөх үеийн тусламжийг цаг үед нь зөв үзүүлэх
4. Төрөх, төрсний дараахан үеийн цус алдалтаас урьдчилан сэргийлэх
5. Эх, ургийн мониторийн хяналт

/88./ Биений юмны мөчлөгийн зохицуулгад ямар эрхтнүүд оролцдог вэ?

1. Их тархины гадар
2. Гипоталамус
3. Гипофиз
4. Өндгөвч
5. Умай

/89./ Өвдөлтгүй төрүүлэх аргад тавигдах шаардлага юу вэ?

1. Базлалтын хүч сулруулахгүй
2. Төрөлт удаашруулдаггүй
3. Хойтох ба төрсний дараах хэвийн явцад нөлөөлөхгүй
4. Урагт харш нөлөө үзүүлэхгүй
5. Бүх жирэмсэн эмэгтэйд хэрэглэж болох энгийн байх

/90./ Үрийн шингэнийг шинжлэх үед ямар зарчим баримтлах вэ?

1. Үрийн шингэн авахаас 1-3 хоногийн өмнө бэлгийн харьцаа хийхгүй байх
2. Үрийн шингэн авахаас 3-7 хоногийн өмнө бэлгийн харьцаа хийхгүй байх
3. Үрийн шингэнийг ариутгасан металл саванд авна
4. Үрийн шингэнийг ариутгасан шилэн саванд авна
5. Үрийн шингэнийг 25-30° -т байлгана

/91./ Бага аарцагийн хавтгайнуудыг нэрлэнэ үү?

1. Орох хэсгийн хавтгай
2. Хөндийн хэсгийн хавтгай
3. Гарах хэсгийн хавтгай
4. Дээд хэсгийн хавтгай
5. Доод хэсгийн хавтгай

/92./ Ураг өгзгөөр түрүүлсэн, I нуруулалт ургийн зүрхний цохилт хаана тод сонсогдох вэ?

- A. Хүйснээс доош, зүүн талд
- B. Хүйснээс дээш, баруун талд
- C. Хүйсний хажуу талд
- D. Хүйснээс дээш, зүүн талд
- E. Хүйснээс доош, баруун талд

/93./ Бөгс түрүүлсэн үеийн төрлөгийн биомеханизмын 3- р үе:

- A. Өгзөг доошлоно
- B. Өгзөг дотор эргэнэ
- C. Өгзөг цухуйна
- D. Өгзөг цухалзана
- E. Толгой дотор эргэх

/94./ Өвөр янзтай дагз түрүүлсэн байхад ургийн толгой бага аарцгийн орох хэсгийн ямар хэмжээгээр ордог вэ?

- A. Шулуун хэмжээнд

- В. Баруун ташуу хэмжээнд
 - С. Хөндлөн хэмжээнд
 - Д. Ташуу ба хөндлөн хэмжээнд
 - Е. Зүүн ташуу хэмжээнд
- /95./ Орой түрүүлэлтийн үед эхэлж төрөх нь
- А. Дух
 - В. Цох
 - С. Хамар
 - Д. Их зулай
 - Е. Бага зулай
- /96./ Distantio cristarum хэмжээ нь:
- А. Ташаа ясны дэлбээний алслагдсан зай
 - В. Дунд чөмөгний том төвгөрүүдийн хоорондох зай
 - С. Ташаа ясны урд дээд сэртэнгийн хоорондох зай
 - Д. Умдагны дээд ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмын арын сэртэн хүртэлх хэмжээ
 - Е. Умдагны доод ирмэгээс хонцог хүртэлх хэмжээ
- /97./ Жирэмсний хожуу хордлоготой эхийг хэн төрүүлэх вэ?
- А. Ерөнхий мэргэжлийн их эмч
 - В. Багийн бага эмч
 - С. Эх баригч
 - Д. Мэргэжлийн их эмч
 - Е. Мэргэжлийн их эмч, бусад нарийн мэргэжлийн эмчтэй хамтран
- /98./ Манайд хэдэн хүүхэдтэй байх нь хамгийн тохиромжтой гэж үздэг вэ?
- А. 1-2 хүүхэд
 - В. 2-3 хүүхэд
 - С. 3-5 хүүхэд
 - Д. 5-7 хүүхэд
 - Е. 8-аас дээш
- /99./ Distantio spinarum нь хэдэн см вэ?
- А. 24-25 см
 - В. 30-31 см
 - С. 26-27 см
 - Д. 25-26 см
 - Е. 28-29 см
- /100./ Ураг дагуу байрлалтай, өвөр янзын дагз түрүүлэлт, 2-р хэлбийлттэй үед толгой аарцгийн амсарт тавигдах үеийн байдлыг хэлнэ үү.
- А. Суман заадас баруун ташууд бага зулай баруун ардаа
 - В. Суман заадас зүүн ташуу хэмжээнд бага зулай баруун урд
 - С. Суман заадас баруун ташуу хэмжээнд бага зулай урдаа
 - Д. Суман заадас баруун ташууд бага зулай зүүн урдаа
 - Е. Суман заадас зүүн ташуу хэмжээнд бага зулай баруун ардаа
- /101./ Жирэмсний 36-37 долоо хоногтойд ураг орчмын шингэн гарч 7 цаг болж байгаа, төрөх зам төрөлтөнд бэлтгэгдсэн, халдварын болон ураг бүтэлтийн шинж тэмдэг илрээгүй. Төрөлтийг яаж шийдвэрлэх вэ?
- А. Яаралтай
 - В. Төрөлтийг идэвхтэй удирдаж төрүүлнэ
 - С. Хяналтанд байлгана
 - Д. Хүлээх тактик баримталж төрүүлнэ
 - Е. Төлөвлөгөөт кессар хагалгаагаар төрүүлнэ
- /102./ Урд янз, дагз түрүүлэлтийн үед аарцгийн хөндийн уйтан хэсэгт ургийн толгойн суман заадас ямар хэмжээнд байх вэ?
- А. Шулуун
 - В. Баруун ташуу
 - С. Зүүн ташуу
 - Д. Ташуу ба шулуун хэмжээнд ойртсон
 - Е. Хөндлөн хэмжээнд

/103./ Ихэс бүрэн төрүүлсэн үед төрөлтийг шийдэх хамгийн зөв арга

- A. Төрөлтийг сэдээж төрөх замаар төрүүлнэ
- B. Яаралтай кесар хагалгаанд оруулж төрүүлнэ
- C. Төрөлтийг хүлээж төрөх замаар төрүүлнэ
- D. Ургийн шингэний хальсыг ярж төрөлтийг дэмжинэ
- E. Эх барихын хавчуур тавьж төрүүлнэ

/104./ Эмнэл зүйн уйтан аарцаг хэдийд оношлогдох вэ?

- A. Жирэмсний явцад
- B. Жирэмсний төгсгөлд
- C. Эх барихын анхны үзлэгээр
- D. Төрлөгийн явцад
- E. Аарцаг хэмжилтээр

/105./ Хэвийн үед ургийн зүрхний цохилтын тоо 1 хоромд хэд байх вэ?

- A. 90-100
- B. 100-110
- C. 110-160
- D. 160-170
- E. 170-180

/106./ Үтрээний үзлэгээр умайн хүзүү хатуу, урт, хөөмий нь хаалттай бол төрөлтийн аль үеийг илэрхийлэх вэ?

- A. Төрлөг эхлээгүй
- B. Төрлөг дөнгөж эхэлж байгаа
- C. Төрлөг удахгүй эхэлнэ
- D. Төрөлтийн далд шат
- E. Дуншилт

/107./ Суман заадас аарцгийн орох хэсгийн аль нэг ташууд юмуу хөндлөн хэмжээнд байна. Төрлөгийн биомеханизмын хэддүгээр момент вэ?

- A. I момент
- B. II момент
- C. III момент
- D. IV момент
- E. V момент

/108./ Хэвийн явцтай жирэмсэнг хэдэн удаа үзэх вэ?

- A. 5 удаа
- B. 7 удаа
- C. 6 удаа
- D. 8 удаа
- E. 9 удаа

/109./ Партограмм гэдэг нь:

- A. Эмгэг төрөлтийг илтгэсэн мэдээлэл
- B. Төрөлтийн үеийн онцлог, үтрээний үзлэгээр умайн хүзүүний нээлтийг үнэлсэн графикт мэдээлэл
- C. Эхийн сайн талын үнэлгээ
- D. Төрөлтийн далд шатыг илтгэсэн мэдээлэл
- E. Төрөлтийн 1 ба 2-р үеийг илтгэсэн мэдээлэл

/110./ Зулбалт гэдэг нь

- A. Жирэмсний 12 долоо хоногтойд үр хөврөл умайгаас гарах
- B. Жирэмсний 22 долоо хоногийн дотор үр хөврөл. ураг умайгаас зориудаар эсвэл өөрөө аяндаа гарах
- C. Жирэмсний 28 долоо хоногийн дотор ураг умайгаас зориудаар гарах
- D. Жирэмсний 22-28 долоо хоногийн турш цус гарах
- E. Жирэмсний 28 долоо хоногийн дотор үр хөврөл, ураг умайгаас өөрөө аяндаа гарах

/111./ Жирэмсний төгсгөл дэх умайн жин

- A. 700-800г
- B. 801-900г
- C. 901-1000г

- D. 100-1200 г
E. 1200-1500 г
- /112./ Нэг удаагийн биений юм ирэх үед гарах цусны хэмжээ хэдэн мл байдаг вэ?
A. 20-30 мл
B. 30-50 мл
C. 60-80 мл
D. 80-100 мл
E. 100--120 мл
- /113./ Бүрэн биш зулбалтын үед дараах арга хэмжээ авна
A. Умай агшаах бодис хийнэ
B. Умайн хөндийг багажаар цэвэрлэж үр хөврөлийн үлдэгдэл, ихсийн эдийг авна
C. Цус тогтоох зорилгоор 10% -10 мл кальци хлорид тарина
D. Умайн хөндийг цэвэрлэж үр хөврөлийн үлдэгдэл, ихсийн эдийг аваад умай агшаах бэлдмэл тарина
E. Цус багадлын эмчилгээ хийнэ
- /114./ Conjugata externa хэмжээ нь:
A. Умдагны дээд дотор ирмэгээс ууцны төвгөр хүртэлх хэмжээ
B. Умдагны доод ирмэгээс ахар сүүлны орой хүртэлх хэмжээ
C. Умдагны доод ирмэгээс ууц ахар сүүлний нийлэх хэсэг
D. Умдагны гадна дээд ирмэгээс бүсэлхийн 5-р нугалмын арын сэртэн хүртэлх хэмжээ
E. Умдагны дунд хэсгээс ууцны 2, 3-р нугалам хүртэлх хэмжээ
- /115./ Анхан төрөгчийн төрлөгийн II үеийн үргэлжлэх дундаж хугацаа хэд байх вэ?
A. 0. 5 цаг
B. 0. 5-1 цаг
C. 1-2 цаг
D. 2-3 цаг
E. 1 цаг
- /116./ Орчин үед төрсөн нярайн жин, өндөр ямар байхад төрөлт гэж тооцох вэ?
A. 500 гр-аас дээш жинтэй 25 см-ээс дээш урттай
B. 1000 гр-аас дээш жинтэй 35 см-ээс дээш урттай
C. 1500 гр-аас дээш жинтэй 40см-ээс дээш урттай
D. 2000 гр-аас дээш жинтэй 45см-ээс дээш урттай
E. 2500 гр-аас дээш жинтэй 47см-ээс дээш урттай
- /117./ Үтрээний үзлэгээр бага зулай хэрхэн тэмтрэгдэх вэ?
A. Том ромбо хэлбэртэй
B. Жижиг ромбо хэлбэртэй
C. Том гурвалжин хэлбэртэй
D. Жижиг гурвалжин хэлбэртэй
E. Умдагт ойрхон тэмтрэгдэнэ
- /118./ Хамгийн ашигтай төрөх нас аль нь вэ?
A. 18-20 нас
B. 20-35 нас
C. 21-25 нас
D. 26-30 нас
E. 30-35 нас
- /119./ Дагз түрүүлэлт урд янзын үед аарцгийн гарах хэсэгт ургийн толгойн байдал ямар байх вэ?
A. Суман заадас хөндлөн хэмжээнд бага зулай зүүн талд
B. Суман заадас шулуун хэмжээнд бага зулай урдаа
C. Суман заадас баруун ташууд бага зулай урдаа
D. Суман заадас зүүн ташууд бага зулай ардаа
E. Суман заадас шулуун хэмжээнд бага зулай ардаа
- /120./ Ихэнх тохиолдолд төрлөг удирдах ашигтай арга аль нь вэ?
A. Хүлээж төрөх замаар төрүүлэх
B. Кесар хагалгаа хийх
C. Ургийн шингэний хальс цоолох

- D. Окситоцин тарих
- E. Төрөлтийг эмээр сэдээх

/121./ Жирэмсэн эмэгтэйд цус багадалтаас сэргийлэх зорилгоор төмрийн бэлдмэлийг хэрэглэх зохимжтой тун

- A. 30-60 мг
- B. 60-100 мг
- C. 100-15 мг
- D. 150-200 мг
- E. 200-300 мг

/122./ Уйтан аарцагтай үед жирэмсний эхний хагаст гарах хүндрэл

- A. Хэвийн байрласан эхэс хугацаанаасаа өмнө ховхрох
- B. Эхэс түрүүлэлт
- C. Умай урагдах шинж илэрнэ
- D. Ураг орчмын шингэн эрт гарна
- E. Жирэмслэлт хэвийн явагдана

/123./ Анхан төрөгчийн төрлөгийн I үеийн үргэлжлэх дундаж хугацаа хэд байх вэ?

- A. 3-5 цаг
- B. 6-9 цаг
- C. 10-12 цаг
- D. 14-16 цаг
- E. 16-18 цаг

/124./ Хэвийн явцтай давтан төрөлтийн 1-р үед умайн хүзүүний нээлтийн хурд цагт дунджаар хэдэн см байх вэ?

- A. 3см
- B. 1 см
- C. 1. 5 см
- D. 0. 5 см
- E. 0.5-1 см

/125./ Ургийн өврийн янзтай дагз түрүүлсэн байхад хөтлөх цэг нь юу вэ?

- A. Бага зулай
- B. Их зулай
- C. Их бага зулайн дунд хэсэг
- D. Шилний хонхор
- E. Духны үстэй хэсэг

/126./ Суман заадас шулуун хэмжээнд ургийн нуруу арагшаа харсан

- A. Толгой түрүүлсэн урд янз
- B. 1-р хэлбийлт урд янз
- C. 2-р хэлбийлт урд янз
- D. Толгой түрүүлэлт арын янз
- E. Оройн төрүүлэлт

/127./ Бөгс түрүүлсэн төрлөгийн 1-р үед үүсч болох хүндрэлд хамаарахгүй вэ?

- A. Төрөх хүчний анхдагч сулрал
- B. Ураг орчмын шингэн эрт гарах
- C. Хүйн гогцоо унжих
- D. Ургийн хөл унжих
- E. Ургийн толгой гэдйх

/128./ Нүүр төрүүлэлтийн үед ургийн толгой аарцгийн орох хэсэгт ямар хэмжээгээр тавигдах вэ?

- A. Бага ташуу
- B. Дунд ташуу
- C. Их ташуу
- D. Шулуун
- E. Босоо

/129./ Дагз түрүүлсэн өвөр янзтай 1-р нуруулалтын үед ургийн зүрхний цохилт хаана хамгийн тод сонсогдох вэ?

- A. Хүйсний баруун доор

- В. Хүйсний зүүн доор
- С. Хүйсний зүүн дээр
- Д. Хүйсний түвшинд зүүн талдаа
- Е. Хүйсний баруун дээр

/130./ Төрөлтийн 2-р үед хэдий үеэс эх барихын гардан тусламж үзүүлж эхлэх вэ?

- А. Умайн амсар бүрэн нээгдсэн үеэс
- В. Ургийн толгой бага аарцгийн гарах хэсэгт тулж ирсэн үеэс
- С. Ургийн толгой цухалзах үеэс
- Д. Ургийн толгой цухуйсан үеэс
- Е. Ургийн толгой гарах үеэс

/131./ Бүрэн биш зулбалтын үед илрэх шинж тэмдэг

- 1. Үтрээнээс цус ихээр гарна
- 2. Умай базалж өвдөнө
- 3. Умайн хүзүү нээлттэй
- 4. Умай жирэмсний хугацаатай тохирохгүй
- 5. Цус багадалт илэрнэ

/132./ Жирэмсний хожуу хордлогын ангилал

- 1. Манас таталтын урьдалын хөнгөн хэлбэр
- 2. Манас таталтын урьдалын хүнд хэлбэр
- 3. Манас таталт
- 4. Усан хаван
- 5. Невропати

/133./ Эмнэл зүйн уйтан аарцгийн шалтгаан юу вэ?

- 1. Том ураг
- 2. Ургийн толгойн буруу тавилт
- 3. Ургийн толгойн усжилт
- 4. Өвчлөмтгий байдал
- 5. Ургийн шингэн эрт гарах

/134./ Жирэмсэн үед амьсгалын эрхтэн системд дараах өөрчлөлт гарна:

- 1. Уушгины багтаамж нэмэгдэнэ
- 2. Хүчилтөрөгчийн хэрэгцээ ихэснэ
- 3. Амьсгалын тоо олширно
- 4. Ачаалалтай болно
- 5. Цээж өргөснө

/135./ Ихсийн үүрэг:

- 1. Ургийг тэжээх
- 2. Хамгаалах
- 3. Ургийн бодисын солилцооны бүтээгдэхүүнийг ялгаруулах
- 4. Амьсгалах
- 5. Синтезлэх

/136./ Жирэмсний эргэлзээтэй шинжүүдийг нэрлэ

- 1. Өглөөгүүр бөөлжих
- 2. Үнэрлэх мэдрэхүйн өөрчлөлт
- 3. Цочромхой эсвэл унтамхай болох
- 4. Хэвлийн цагаан шугам тодрох
- 5. Хоолны дуршил өөрчлөгдөх

/137./ Төрөлтийн I үеийн явцад үзүүлэх дэмжих тусламжийг дурьдана уу.

- 1. Төрөлтийн явц, ахицын талаар түүнд мэдээлж байна.
- 2. Үзлэг бүрийн өмнө гадна бэлэг эрхтэн ба хярзанг угаана.
- 3. Давсгыг 2 цаг тутамд суллаж байхыг төрөгч эхэд зөвлөнө.
- 4. Төрөлтийн 1-р үеийн туршид эмэгтэй чөлөөтэй хөдөлж явахыг зөвшөөрнө.
- 5. Эмэгтэйг тайван байлгах нөхцлийг бүрдүүлэхийн тулд ганцаар нь байлгана.

/138./ Жирэмсэн үед яагаад шээсний замын үрэвсэл үүсдэг вэ?

- 1. Прогестероны нөлөөгөөр шээс дамжуулах суваг өргөсөнө
- 2. Умай баруун тийш хазайж, шээс дамжуулах суваг дарагдах
- 3. Бөөрний тэвшинцэр, давсаг тэлэгдэж агчил нь сулардаг

4. Бөөрний судас нарийссанаас
 5. Умай зүүн тийш хазайдгаас
- /139./ Бага аарцгийн хөндийн уйтан хэсгийн хэмжээнүүд аль нь вэ?
1. Хоёр талын сүүжний хонхруудын дотор зай-12. 5 см
 2. Хоёр талын суудлын сэртэнгүүдийн хоорондох зай-10. 5 см
 3. Умдагны үений дунд дотор голоос ууцны II. III үеийн зааг хүртэл-12. 5 см
 4. Умдагны үений доод ирмэгээс ууц-ахар сүүлний үе хүртэл-11. 5 см
 5. Ташуу хэмжээ-12 см
- /140./ Цус алдалтын дайрлага үүсэх шалтгаан
1. Хэвийн байрласан ихэс цагаас өмнө ховхрох
 2. Умайн урагдал
 3. Умайн булчин агшилтгүй болох
 4. Умайн булчингийн сулрал
 5. Ихэс түрүүлэлт
- /141./ Эх барихын тусгайлсан асуумжаар дараах зүйлүүдийг тодруулна.
1. Жирэмслэлт, төрөлтийн тоо
 2. Түрүүчийн жирэмслэлт, төрөлтийн явц. хүндрэл
 3. Сүүлчийн сарын тэмдэг
 4. Төрүүлсэн хүүхдийн жин, амьд эсэх, гарсан хүндрэл
 5. Эх барихын ба эмэгтэйчүүдийн ямар нэг мэс ажилбар хийлгэж байсан эсэх
- /142./ Умайн үүрэг:
1. Ургийг тээж төрүүлнэ
 2. Биений юмны үед умайн салст хуурч гадагшилна
 3. Үр тогтсон өндгөн эсийг бэхлэх
 4. Эм бэлгийн дааврыг ялгаруулна
 5. Үр тогтолт явагдана
- /143./ Төрлөгийн I үе эхэлсэн шинжүүд юу байх вэ?
1. Ургийн бүрхүүл хальсны хэлбэршилт
 2. Умайн хүзүүний толийлт ба нээгдэлт
 3. Жигд базлалт
 4. Ургийн толгой бага аарцгийн гарах хэсэгт
 5. Умайн хүзүү бүрэн нээгдсэн
- /144./ Жирэмсэн үед цус алдах шалтгаанд ямар ямар эмгэг орох вэ?
1. Зулбалт
 2. Умайн гадуурхи жирэмсэн
 3. Хэвийн байрласан эхэс хугацаанаасаа өмнө ховхрох
 4. Ихэс түрүүлэлт
 5. Өсөлтгүй жирэмсэн
- /145./ Жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэртэй үед төрөлтийн I үеийг яаж удирдах вэ?
1. Эх баригч, эмч байнга дэргэд нь байна
 2. Өргөн сэтгүүртэй систем судсанд залгана
 3. Чимээ шуугиангүй, гэрэлгүй өрөөнд сувилна
 4. Партограммын үзүүлэлтүүдийг хянаж тэмдэглэнэ
 5. Аливаа үйлдлийг гүн мэдээгүйжүүлгийн дор хийнэ
- /146./ Төрөлтийн 3-р үеийг идэвхтэй удирдах ямар ач холбогдолтой вэ?
1. Хойдохын үе богиносно
 2. Хойдохын ба төрсний дараах цус алдалт багасна
 3. Умайд эхэс түдэх хүндрэлийн давтамж нэмэгдэхгүй
 4. Умайн агшилт сайжирна
 5. Ихэс төвөөсөө ховхрох давтамжийг багасгана
- /147./ Умайн салстын үрэвсэлд нөлөөлөх хүчин зүйлс
1. Биений юм ирэх
 2. Үр хөндөлт
 3. Эмгэг төрөлт
 4. Умайн хөндийд хийгдэх ажилбарууд
 5. Дааврын өөрчлөлт

/148./ Аарцгийн хөгжил ямар хүчин зүйлүүдийн улмаас алдагдаж болох вэ?

1. Хоол тэжээлийн дутмагшил
2. Хүнд явцтай эмгэгүүд
3. Рахит
4. Сүрьеэ
5. Эрдэс, витамины дутмагшил

/149./ Жирэмсний хордлогын ерөнхий ангилал:

1. Презклампси хөнгөн хэлбэр
2. Эрт үеийн хордлого
3. Презклампси хүнд хэлбэр
4. Хожуу үеийн хордлого
5. Эклампси

/150./ Төрөлтийн III үеийг идэвхтэй удирдахад хамаарахгүй үйлдэл:

1. Умай агшаах эмийн бодис тарина
2. Хяналтын дор хүйнээс татна
3. Умай агшихад дээш нь сойно
4. Умайг дээш түлхэхгүй
5. Умайд иллэг хийнэ

/151./ Ихсийн анатомийн бүтцийг тоочно уу.

1. Олон тооны салаалсан цэлмэнгүүдээс бүрдэнэ
2. Дугариг улаан саарал өнгөтэй
3. Зузаан нь 2-3 см, голч нь 15-18 см
4. 18-20 хэлтэнцрээс тогтоно
5. Махархуу бүтэцтэй

/152./ Нярайн хяналт:

1. Нярайн амьсгал, арьсны өнгийг 5 хором бүр шалгана
2. Хүүхдийн хүйнээс цус гарч буй эсэхийг 15 хором тутамд шалгана
3. Хүүхдийн дулааныг 15 хором бүр хөлийг нь үзэж шалгана
4. Нярайн амьсгал, арьсны өнгийг 15 хором бүр шалгана
5. Хүүхдийн хүйнээс цус гарч буй эсэхийг 5 хором тутамд шалгана

/153./ Жирэмсний хожуу хордлогын хөнгөн хэлбэртэй байхад суларлын даралт хэдэн мм МУБО хүртэл байх вэ?

1. 90
2. 95
3. 100
4. 105
5. 110

/154./ Ихэсийн хэсэг үлдсэний улмаас төрсний дараах хоёрдогч цус алдалт үүссэн бол ямар арга хэмжээ авах вэ

1. Сумын эмнэлэгт бага эмч умайн хөндийг цэвэрлэнэ
2. Мэргэжлийн эмчтэй газар шилжүүлнэ
3. Зөвлөгөө өгч гэрээр эмчилнэ
4. Үрэвслийн эсрэг эмчилгээг даруй эхэлнэ
5. Умай агшаах тариа хийж ажиглана

/155./ Пиелонефриттэй жирэмсэнд шээсний ерөнхий шинжилгээнд ямар өөрчлөлт илрэх вэ

1. Шээсээр уураг ялгарах- Протейнурия
2. Шээсэнд нян илрэх- Бактериурия
3. Шээсэнд бортгон хучуур илрэх- Цилиндрурия
4. Шээсэнд цагаан цогцос илрэх- Лейкоцитурия
5. Шээс цустай гарах- Гематурия

/156./ Жирэмсний бөөлжилтийн хөнгөн хэлбэрийн үед илрэх шинжийг нэрлэнэ үү?

1. Хоолны дараа өдөрт 3-4 удаа бөөлжинө
2. Пульс бага зэрэг олширно
3. АД хэвийн
4. Хоолонд дургүй
5. Биеийн жин хэвийн

/157./ Жирэмсэн үед зүрх судасны системд гарах өөрчлөлт:

1. Эргэлдэх цусны хэмжээ 35-40%-р ихэснэ
2. Зүрхний ховдол томорно
3. Өрц дээшилнэ
4. Судасны цохилт өөрчлөгдөхгүй
5. Зүрхний минутын багтаамж буурна

/158./ Жирэмсэн ба төрөх үед зүрхэнд ачаалал ихсэх эгзэгтэй үеийг дурьдана уу.

1. Төрөлтийн II үед ачаалал нэмэгдэнэ
2. Ихэс салах үед цусны эргэлтэнд огцом өөрчлөлт ордог
3. Жирэмсний 26-36 долоо хоногт эргэлдэх цусны хэмжээ хамгийн их болно
4. Төрсний дараа цусны эргэлтэнд огцом өөрчлөлт гарна
5. Жирэмсэн ба төрөлтийн бүх үед зүрхэнд ачаалал ихсэх эгзэгтэй

/159./ Ургийн толгой бага аарцгийн гарах хэсэгт байгаагийн шинж:

1. Гадуур үзлэгээр барьж үзэхэд ургийн толгой баригдахгүй –0/5
2. Суудал ясны сэртэнд хуруу хүрэхгүй
3. Умдаг ясны дотор бүх гадаргууг толгой эзэлсэн
4. Суман заадас гарах хэсгийн шулуун хэмжээнд давхацсан
5. Умайн хүзүү бүрэн нээгдсэн

/160./ Пиелонефриттэй жирэмсэнд ямар антибиотیکیг хэрэглэхгүй вэ

1. Ампициллин
2. Тетрацилин
3. Пенициллин
4. Гентамицин
5. Оксациллин

/161./ Биений юмны мөчлөгийн шинж чанар:

1. Дунджаар 28 хоногийн мөчлөгтэй
2. 3-6 хоног үргэлжилдэг
3. Гарах цусны хэмжээ 30-50 мл
4. Хоёр мөчлөгтэй
5. Мөчлөг нь тогтмол байх

/162./ Аль нь гүйцэт нярайн шинж вэ?

1. 3200,0 гр жинтэй
2. Хумс өндгөө давж ургасан
3. Толгойн үс 2 см
4. Арьс улаан
5. 45 см урт

/163./ Манас таталтын урьдлын хөнгөн хэлбэр

1. Артерийн даралт 110 ммуб-с их
2. Шээсэнд уураг 300 мг-с бага
3. Бүх биеэр хавагнана
4. Сулралын даралт 110ммуб-с бага
5. Аюултай шинжүүд илэрнэ

/164./ Аарцаг түрүүлэлтийн үед эх барихын гадуур үзлэгээр ямар шинж тэмдэг илрэх вэ

1. Умайн ёроолын өндөр дээр тэмтрэгдэнэ
2. Аарцгийн орох хэсгийн дээр зөөлөн хөдөлгөөн багатай хэсэг тэмтрэгдэнэ
3. УЗЦ хүйснээс дээр сонсогдоно
4. Аарцгийн орох хэсгийн дээр хатуу, хөдөлгөөн багатай хэсэг тэмтрэгдэнэ
5. Умайн ёроолд зөөлөн хөдөлгөөн багатай хэсэг тэмтрэгдэнэ

/165./ Пиелонефриттэй жирэмсэн эмэгтэйд хийгдэх асаргаа сувилгаа

1. Шингэнийг сайн уулгах
2. Эсрэг талаар нь хэвтүүлнэ
3. Өвдөг, тохойн байрлалд 5-10 мин байлгана
4. Хөдөлгөөнийг хорихгүй
5. Давсгүй хоол өгнө

/166./ Жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэрийн эмчилгээний зарчимд хамаарахыг нэрлэнэ үү?

1. Таталт үүсэхээс сэргийлэх
2. Төрөлтийн үйл ажиллагаа эхэлтэл хүлээх
3. Артерийн даралтыг буулгах
4. Шингэн сэлбэх
5. Жирэмслэлтийг шийдэх

/167./ Хэвийн төрөлтийн I үед:

1. АД-ыг 4 цаг тутам үзэж тэмдэглэнэ
2. Умайн базлалтын давтамж, үргэлжлэх хугацааг хянана
3. УЗЦ-ыг 30 минут тутамд сонсож тэмдэглэнэ
4. Эхийг зөв дүлүүлэх
5. Шээсийг ариун шээлгүүрээр авна

/168./ Жирэмсний хожуу хугацаанд цус алдах нь ямар шалтгаантай вэ?

1. Ихэс түрүүлэлт
2. Умайн урагдал
3. Хэвийн байрласан ихэс ховхрох
4. Дутуу төрөлт
5. Зулбах

/169./ Ихэсээр нэвтрэх бодисуудыг нэрлэнэ үү?

1. Эфир
2. Никотин
3. Спирт
4. Морфин
5. Хор

/170./ Жирэмснийг оношлох Горвиц-Гегарын шинж

1. Дотуур үзлэгээр гадна, дотор хуруу их ойртоно.
2. Жирэмсний эрт үед илэрнэ
3. Умайн хүзүүвч орчим илүү зөөлөрнө
4. Умай урагш нугаларна
5. Умай агшиж хатуурна

/171./ Цус алдалтын дайрлагын үед өвчтөний арьсанд гарах өөрчлөлт

1. Арьс халуун чийглэг
2. Арьс цагаарч саарал туяатай болно
3. Арьс улаан саарал туяатай болно
4. Арьс хүйтэн чийглэг
5. Арьс хүйтэн хуурай

/172./ Жирэмсэн эмэгтэйд үзлэгээр дараах зүйлүүдийг заавал үзэж тэмдэглэнэ

1. Артерийн даралтыг 2 гарт
2. Биеийн жинг нимгэн хувцастай үзэх
3. Биеийн өндрийг хэмжих
4. Судасны цохилт
5. Амьсгалын тоо

/173./ Михаэлисын ромбын хязгаар:

1. Бүсэлхийн 5-р нугалмын арын сэртэн
2. Ташаа ясны ар дээд сэртэн
3. Ууцны орой
4. Нурууны том булчин
5. Өгзөгний булчин

/174./ Бэлэг эрхтний үрэвсэлт өвчинг үүсгэдэг гадаад шалтгааныг нэрлэнэ үү?

1. Дотоод шүүрлийн булчирхайн хямрал
2. ТМС-ийн зохицуулга алдагдах
3. Өнчин тархины хавдар
4. Эмгэг төрүүлэгч нян, вирус
5. Хэт даарах

/175./ Презклампси гэдэг нь:

1. Артерийн даралт ихсэнэ
2. Хавагнана

3. Шээсээр уураг ялгарна
 4. Жирэмсний 22 долоо хоногоос өмнө илэрнэ
 5. Бие даасан өвчин
- /176./ Аарцаг түрүүлэлтийн үед үтрээний үзлэгээр ямар шинж тэмдэг илрэх вэ
1. Умайн хүзүүгээр хатуу зүйл тэмтрэгдэнэ
 2. Умайн хүзүүгээр зөөлөн зүйл тэмтрэгдэнэ
 3. Умайн хүзүүгээр суман заадас тэмтрэгдэнэ
 4. Умайн хүзүүгээр өсгий, хөлийн хуруунууд тэмтрэгдэнэ
 5. Умайн хүзүүгээр бага зулай тэмтрэгдэнэ
- /177./ Хэвийн төрөлтийн I үед дараах үзүүлэлтүүдийг заавал хянаж тэмдэглэнэ
1. Умайн базлалтыг 30 мин-д үзэх
 2. Ургийн зүрхний 2 цаг мин тутамд үзэж тэмдэглэх
 4. Умайн хүзүүний байдлыг 4 цаг тутамд дотуур үзлэг хийж үнэлэх
 5. Шээсний гарцыг 2 цаг тутамд үзэх
- /178./ Жирэмсэн үед пиелонефритээр өвчлөх нь ямар хүндрэлд хүргэх вэ?
1. Ургийн халдвар
 2. Жирэмсний хожуу хордлого үүсэх
 3. Дутуу төрөх
 4. Ургийн шингэн эрт гарах
 5. Төрсний дараа халуурах
- /179./ Өндгөвчийн үйл ажиллагаа:
1. Фоллукул үечлэлтэй боловсорч хөгжинө
 2. Эстроген. прогестрон даавруудыг ялгаруулна
 3. Үр тогтох чадвартай өндгөн эсийг боловсруулж гаргана
 4. Шар бие үүсч хөгжинө
 5. Жирэмслэхэд овуляци болохгүй
- /180./ Жирэмсэн үед сүрьеэ илрүүлэх асуумж:
1. Өмнө нь сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байсан уу?
 2. 14 хоногоос дээш хугацаагаар хаиалгаж байсан уу?
 3. Цэр, цустай цэр гарч байна уу?
 4. Шалтгаангүй халуурч байна уу?
 5. Шөнөдөө хөлөрч байна уу?
- /181./ Аарцгийн булчингууд нь ямар үүрэгтэй вэ?
1. Дотор бэлэг эрхтнийг хэвийн байрлалд барих
 2. Хэвлийн доторх даралтыг зохицуулна
 3. Төрөх үед булчингууд нь тэлэгдэж өргөн хоолой болно
 4. Дотор эрхтний тулгуур болно
 5. Бэлэг эрхтнийг халдвараас хамгаалах
- /182./ Төрөлтийн III үеийн асаргаа
1. Нярайг амлуулна
 2. Давсгийг суллана
 3. Алдсан цусыг хэмжинэ
 4. Умайд иллэг хийнэ
 5. Хэвлийд хүйтэн жин тавина